

2.1. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН УВС АЙМАГТАЙ ХОЛБООТОЙ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ(Ж-4.6,Х-3-2.1)

Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тус аймагтай холбоотой нэр зааж дэвшүүлсэн 11 зорилтын хэрэгжилт **97.3** хувьтай байна.

Заалтын дугаар	Зорилт, арга хэмжээ	Биелэлт	Хувь
Хоёр. Бодит салбарын хөгжлийн бодлого			
Зорилт 5. Бодит салбарын хөгжлийг дэмжинэ:			
5.9	Увс аймгийн төвд дулааны шинэ эх үүсвэр барих асуудлыг судалж шийдвэрлэх	Дулааны шинэ эх үүсвэр баригдах асуудал шийдвэрлэгдэж, ТЭЗҮ хийгдэж ЭБЭХЯ-ны шинжлэх ухаан техникийн зөвлөлөөр хэлцэгдэж батлагдав.	100
Зорилт 6. Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаанд тавих эрүүл ахуйн шаардлагыг өндөржүүлж, хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл, аюулгүй байдлыг дээшлүүлнэ:			
6.15.1.	Увс аймагт “Чацаргана” боловсруулах үйлдвэр байгуулах, чацарганы суулгацыг аж ахуйн нэгж, иргэдэд төсөл сонгон шалгаруулж олгох	Чацарганы үрслэгийн сортын бодлого барин үржүүлж байна. Тус аймагт чацарганы 6 төрлийн суулгац үржүүлж, өөрийн аймаг болон Улаанбаатар хот, бусад аймгуудын хэрэгцээнд нийлүүлж байна. УГТЭШХ болон тусгай зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгжүүд 200 гаруй мянган суулгац үржүүлээ. ХХААХҮЯ-наас зарласан тендэрт 2 компани шалгарч, 100-аад мянган суулгац нийлүүлээ. ХХААХҮЯ-аас чацаргана боловсруулах үйлдвэр байгуулахад 500.0 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн бөгөөд гүйцэтгэгчээр нь “Увс хүнс” ХК шалгарч үйл ажиллагаагаа эхлээд байна. Чацарганы суулгац тарих, үржүүлэх, тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагаа явуулах чиглэлээр төсөл ирүүлсэн Улаангом, Малчин, Давст сумдын чацаргана тариалагч 8 иргэн, аж ахуйн нэгжид ЖДҮ-ийг дэмжих сангаас 83.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр 54500 ш суулгац үржүүлэх боломж бүрдлээ.	100
Зорилт 8. Хүн амын ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн дэд бүтцийн салбарыг хөгжүүлнэ:			
8.2	Увс аймгийн нисэх буудлын хатуу хучилттай зурвасыг үерийн далангийн хамт барьж дуусган, цахилгааны шугамтай холбох	Нисэх буудлын хөөрөх, буух зурвасын цемент бетон хатуу хучилттай 2700м замын ажил, үерийн далангийн хамт бүрэн хийгдлээ. Цахилгааны 3.5 км урт 10 квт-ын 2 хос шугам барьж холбосон.	100
8.26	Бүх аймгийн төвийг Улаанбаатар хоттой холбосон хатуу хучилттай авто зам барих ажлыг үргэлжлүүлэх	Улаангом-Тээлийн чиглэлд асфальто бетон хатуу хучилттай зам 15 км хийгдэж ашиглалтанд оров. 2.7 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэв.	100

8.27	Бүх аймгийн төвд хатуу хучилттай шинэ зам барих	Аймгийн төвд 2,99 км хатуу хучилттай замыг засварлан зузаалах ажил хийж дуусган, хүлээлгэн өглөө.	100
8.32	Увс аймгийн төвийн дулааны шинэ эх үүсвэр барих ТЭЗҮ-ийг боловсруулах	Зөвлөх үйлчилгээний тендерийн ажил зохион байгуулан зураг төслийн “Мон-Энержи Консалт” ХХК шалгарч, гэрээний дагуу тус компаниас 11 төрөл мэргэжлийн 16 хүнтэй баг Улаангом сумын дулааны чиглэлээр бүрэн судалгаа хийж 7 хоног ажиллан, тавьсан шаардлагыг бүрэн биелүүлсэн. 148.0 сая төгрөгийн ТЭЗҮ хийгдэж ЭБЭХЯ-ны шинжлэх ухаан техникийн зөвлөлөөр хэлцэгдэж батлагдав.	100
Гурав. Байгаль орчин, бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого			
Зорилт 11. Байгалийн нөөцийн тогтвортой менежментийн үндсийг бэхжүүлж, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний чанар, үр дүнг сайжруулна:			
11.9.2.	Баруун бүсийн зарим нуурын загасны нөөцийг тогтоох ажлыг зохион байгуулах	Айраг, Хяргас нуурт загасны судалгааны ажлыг ОХУ, Монгол улсын хамтарсан иж бүрэн экспедицийн загас судлалын хэсэг, ШУА-ын харъяа Геозкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Мэндсайхан ахлагчтай судлаачид, УНАСУТХГ-ын мэргэжилтэн нарын оролцоотой баг нөөц тогтоох ажлыг хийж гүйцэтгэсэн.	100
11.11.3.	Алтан Хөхий нуруу орчмын газрыг байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авах	Монгол Улсын УИХ-ын 2010 оны 1-р сарын 4-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Өмнөговь сумын Алтан Хөхийн уул орчмын газар нутгийг байгалийн нөөц газрын ангилалд оруулан улсын тусгай хамгаалалтанд авсан болно.	100
Зорилт 15. Хөдөө орон нутгийн хүн амын интернет хэрэглээг нэмэгдүүлж, төрөөс иргэдэд хүргэх мэдээллийг цаг алдалгүй, түргэн шуурхай хүрэх боломжийг бүрдүүлнэ:			
15.6	Улаанбаатар хотын 41 салбар, 21 аймаг, 118 сумын шуудангийн салбарыг нэгдсэн сүлжээнд холбосон мэдээлэл технологийн төв байгуулах	Аймгийн Шуудан үйлчилгээний газар нь “Монгол шуудан” ТӨХК-тай нэгдсэн сүлжээнд холбогдон, мэдээ, лавлагааг Spark болон шуудангийн сүлжээний программаар солилцон ажиллаж байна.	100
Зорилт 35. Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана:			
35.5.1.	Төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймгийн Баруунтуруун, Давст суманд цагдаагийн кобан бариулах ажлыг зохион байгуулах	Баруунтуруун, Давст суманд цагдаагийн кобан баригдаж ашиглалтанд орсон.	100
35.15.	Хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг хөрш орнуудын жишигт хүргэж, хилийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх:	Орос Монголын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 2007 оны 3 сард Боршоо-Хандгайтын шалган нэвтрүүлэх боомтыг олон улсын статустай болгох нот бичигт гарын үсэг зурсан. 2007 оноос хойш энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор рентген	70

**Увс аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаа,
хяналт шинжилгээний тайлан**

2010

	Боршоо-Хандгайт боомтыг олон улсын зэрэглэлд шилжүүлэх	аппарат, видео камер, Гаалийн зурвасын нэвтрэх хэсгийн зорчих хэсгийн өргөтгөл хийж 2 урсгалтай болгосон. Мөн Гаалийн орон сууцны засварт 152.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтажил хийгдсэн. Боршоо боомтын шалган нэвтрүүлэх цогцолборыг барих 1,5 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг шийдэж 2011 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 225.0 сая төгрөгийн ажил хийгдэхээр тусгагдсан байна.	
1	100	10	
2	70	1	
	ДУНДАЧ ХУВЬ	97.3	

УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР